

Есүс Христээс найдвар олох

Христийн ачаар найдвар тээх нь өөр өөр нөхцөл байдалд бидний амьдралд нөлөөлдөг талаар бодоход тань туслахын тулд дараах жишээнүүдээс нэгийг сонго (эсвэл өөрөө нэгийг бодож ол). Үүнд:

Жэймс хаяж чадсан гэж бодож байсан нүгэлт зуршлууддаа эргээд орчихсон.

Бэкзагийн аав сүмд ирэхээ больж, Бурханд ч бас итгэхээ больсон гэдгээ хэлэв.

Аналист сургууль, ажил, гэр орны үүргүүдээ бүгдийг нь биелүүлэхэд хүндрэлтэй байна.

Дараах хоёр өгүүлбэрийг гүйцээгээд, тухайн хүн өөрийн нөхцөл байдлыг хэрхэн өөрөөр харж болохыг дурд. Үүнд:

• Есүс Христэд найдах найдвар үгүй бол, _____

• Есүс Христэд найдах найдвар бий бол, _____

Дараах асуултуудыг авч үзэн ярилц.

- Энэ хүн Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн хэрэгжүүлж чадах вэ? Та хариултдаа багтаах судар олж чадах эсэхээ хараарай.
- Ийм байдлаар итгэлээ хэрэгжүүлэх нь Есүс Христээр дамжуулан илүү их найдвар тээхэд энэ хүнд хэрхэн тусалж болох вэ?
- Хэрэв энэ хүн танаас яагаад Есүс Христэд найддаг тухай асуувал та юу гэж хэлэх вэ?
(1 Петр 3:15-ыг үзнэ үү.)